



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 448

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
гишүүдийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10 дахь заалт, Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай” 202 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2018 оны 05/7711 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлт, Сангийн сайдын 2018 оны 11/5675 дугаар албан бичиг, Эрчим хүчний сайдын 2018 оны а/3173 дугаар албан бичиг, Увс аймгийн Засаг даргын 2018 оны 1/1139 дүгээр албан бичгээр ирүүлсэн саналын дагуу “Улаангомын дулааны хоёрдугаар станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга П.Дорждагва, Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахилгааны хэлтсийн дарга С.Цэрэнжамц, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Ё.Энхтуяа, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Дулааны хэлтсийн мэргэжилтэн М.Балдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Наранчимэг, Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга С.Батжаргал нарыг 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002335